



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Хэрлэн сум

2023 оны цэргийн бүртгэл
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, Хурандаа
Гишүүн	Г.Сэдэдмаа	Статистикийн хэлтсийн дарга
	Б.Төрхүү	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	Л.Цэнддорж	Цэргийн штабын дайчилгааны офицер, Дэд хурандаа
		Сумдын Засаг дарга, Тосгоны захирагч нар
Нарийн бичгийн дарга:	А.Баярбат	Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер, Хошууч

2.2023 оны цэргийн бүртгэлийг 2023 оны 1 дүгээр сарын 09-өөс 2023 оны 1 дүгээр сарын 31-ний хооронд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

3.Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийг холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, цэргийн үүрэгтэн иргэдийг биечлэн болон цахимаар бүртгэж, 2022 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, цэргийн бүртгэлийн материал, мэдээ судалгааг маягтын дагуу гаргаж, хуваарийн дагуу сумын Засаг даргын Тамгын газрын дарга, тосгоны

2.

Захирагчийн ажлын албаны даргаар хүргүүлэхийг сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарт даалгасугай.


4.Цэргийн бүртгэлийн явцтай танилцах, шалган зааварлах хуваарийг нэгдүгээр, сумдын цэргийн бүртгэлийн материал тушаах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

5.Цэргийн бүртгэлийн явцын байдалд хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгөх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, цэргийн бүртгэлийн материалыг тогтоосон хугацаанд сумдаас хүлээн авч зааврын дагуу нэгтгэх, нэгдсэн дүн мэдээг 2023 оны 3 дугаар сарын 10-ны дотор Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэхийг Комиссын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

2023 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН ЯВЦТАЙ
ТАНИЛЦАЖ, ШАЛГАН ЗААВАРЛАХ ХУВААРЬ

д/д	Сумдын нэр	Шалган зааварлах хуваарь	Он, сар, өдөр
1	Мөрөн	Хурандаа Н.Хүрэлээ Дэд хурандаа Л.Цэнддорж Хошууч Э.Батхүрэл	2023.01.16
2	Өлзийт		2023.01.16
3	Жаргалтхаан		2023.01.17
4	Дэлгэрхаан		2023.01.17
5	ХБУлаан		2023.01.18
6	Баянмөнх		2023.01.18
7	Дархан		2023.01.19
8	Бор-Өндөр		2023.01.19
9	Галшар		2023.01.20
10	Баянхутаг		2023.01.20
11	Биндэр		2023.01.23
12	Баян-Адрага		2023.01.23
13	Дадал		2023.01.24
14	Норовлин		2023.01.24
15	Баян-Овоо		2023.01.25
16	Батноров		2023.01.25
17	Бэрх		2023.01.26
18	Тахилгат		2023.01.26
19	Хэрлэн 1 дүгээр баг		2023.01.27
20	Хэрлэн 2 дугаар баг		2023.01.27
21	Хэрлэн 3 дугаар баг		2023.01.28
22	Хэрлэн 4 дүгээр баг		2023.01.28
23	Хэрлэн 5 дугаар баг		2023.01.29
24	Хэрлэн 6 дугаар баг		2023.01.29



Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны

дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

2023 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН
МАТЕРИАЛ ТУШААХ ХУВААРЬ

д/д	Сумдын нэр	Он, сар, өдөр	Цаг	Хариуцах эзэн
1	Цэнхэрмандал	2023.02.06	09.00	Ү.Ичинхорлоо
2	Жаргалтхаан		12.00	Н.Мөнхдэлгэр
3	Мөрөн		15.00	Н.Намжилноров
4	Өмнөдэлгэр	2023.02.07	09.00	Л.Баярмаа
5	Гурванбаян		12.00	Н.Мөнхжаргал
6	Батширээт		15.00	Ш.Эрдэнэчимэг
7	Баян-Адрага		16.00	Б.Мөнхбат
8	Дадал	2023.02.08	09.00	Д.Гэрэлмаа
9	Норовлин		12.00	Х.Баасансрэн
10	Баян-Овоо		15.00	Б.Сарантуяа
11	Дархан	2023.02.09	09.00	П.Ганхэт
12	Баянмөнх		12.00	А.Болортуяа
13	Бор-Өндөр		15.00	З.Ууганжаргал
14	Батноров	2023.02.10	09.00	А.Борчулуун
15	Бэрх		12.00	Н.Мягмарсүрэн
16	Баянхутаг		15.00	Б.Золбоо
17	Галшар		09.00	Н.Мөнхтөр
18	Биндэр	2023.02.13	12.00	Г.Өнөболд
19	Өлзийт		15.00	Д.Ганцэцэг
20	Дэлгэрхаан		09.00	З.Ганбаатар
21	ХБУлаан	2023.02.14	12.00	Ж.Март
22	Хэрлэн 1 дүгээр баг		09.00	Б.Эрдэнэбилэг
23	Хэрлэн 2 дугаар баг	2023.02.15	12.00	Б.Хүрэлзүрх
24	Хэрлэн 3 дугаар баг		15.00	Б.Мөнхбаяр
25	Хэрлэн 4 дүгээр баг		09.00	С.Сарангоо
26	Хэрлэн 5 дугаар баг	2023.02.16	11.00	А.Оюунбилэг
27	Хэрлэн 6 дугаар баг		13.00	Ч.Хэрлэнчимэг
28	Хэрлэн 8 дугаар баг		15.00	А.Ууганбаатар